

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: byanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн
Утас: 70357955 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 85
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үүнд:

1. Томилолтоор явсан нь дэмжигдэхгүй баримтаар 32.9 сая төгрөгийн томилолтын зардал олгосон байна.
2. Цахим Эрдэнэт-1 төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн 60.0 сая төгрөгийн зардлын зарцуулалт анхан шатны нотлох баримтгүй, зардлыг төсвийн хүрээнд зарцуулсан нь нотлогдохгүй байна.
3. Ажил хийгдсэн нь нотлогдохгүй ухаалаг хотын сурталчилгаа хийлгэх зардал 5.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.
4. Ажил хийгдсэн нь нотлогдохгүй гэрээт ажлын хөлс 3.0 сая төгрөг хувь хүний дансанд шилжүүлсэн байна.
5. 2022 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй цахилгааны төлбөр 1.1 сая төгрөгийг тайлант онд шилжүүлсэн байна.
6. Харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдээгүй байна. Эдгээр нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3. Тооцооны үлдэгдлийн баталгаа НХМаягт ТМ-3 "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана." гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 36 дугаар хуралдааны шийдвэрээр 2023 оны бизнес төлөвлөгөөнд орлого 916.6 сая төгрөг, зардал 905.1 сая төгрөгөөр баталснаас 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 41 дүгээр хуралдаанаар орлого 698.4 сая төгрөг, зардал 689.4 сая төгрөгөөр өөрчлөн тодотгон баталж, мөнгөн гүйлгээний тайлангаар орлого 823.7 сая төгрөг, зардал 806.1 сая төгрөг зарцуулсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд компанийн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 42 дугаар тогтоолоор Орхон аймагт таримал мөөгний кластер хөгжүүлэх зорилгоор нийт хувьцааны 19 хувийг 84.2 сая төгрөгийн хөрөнгөөр эзэмших шийдвэртэйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийг үүсгэн байгуулсан байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нэг тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ нь 2023 онд аймгийн Засаг даргатай 6 зорилт, 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 80.6 хувьтай гэж дүгнэсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх

нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2022.12.31	2023.12.31
А	Б	1	2
1.1.1	Мөнгөн хөрөнгө	205,548,887.69	11,359,702.93
1.1.2	Дансны авлага	100,000,000.00	192,600,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,639,729.92	17,142.95
1.1.4	Бусад авлага	569,973,000.00	618,772,000.00
1.1.6	Бараа материал	38,133,508.93	1,037,575,336.20
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	923,295,126.54	1,860,324,182.08
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,465,561,716.51	1,835,408,619.39
1.2.2	Барилга байгууламж орон сууц	1,483,098,090.00	1,483,098,090.00
1.2.3	Хуримтлагдсан элэгдэл	-58,988,284.83	-98,235,521.07
1.2.4	Авто тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
1.2.5	Хуримтлагдсан элэгдэл	-15,458,333.01	-18,958,332.93
1.2.6	Машин тоног төрхөөрөмж /компьютер/	647,262,570.17	723,869,024.72
1.2.7	Хуримтлагдсан элэгдэл	-214,513,171.19	-320,997,130.78
1.2.8	Тавилга эд хогшил	66,021,036.36	66,021,036.36
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл	-27,460,190.99	-34,388,546.91
1.2.2	Биет бус хөрөнгө	1,260,000.00	863,080,000.00
1.2.3	Биет бус хөрөнгө программ хангамж	3,800,000.00	865,800,000.00
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	-2,540,000.00	-2,720,000.00
1.2.5	Урт хугацаат хөрөнгө оруулалт	100,000,000.00	100,000,000.00
1.1.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	250,000,000.00	250,000,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,816,821,716.51	3,048,488,619.39
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,740,116,843.05	4,908,812,801.47
2.1.1.1	Дансны өглөг	637,000,000.00	761,850,000.00
2.1.1.3	Татварын өр	0.00	985,541.55
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	637,000,000.00	762,835,541.55
2.3.1	Өмч: а) төрийн	1,150,103,063.75	1,150,103,063.75
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,080,692,610.00	3,445,244,610.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	-127,678,830.70	-449,370,413.83
2.3.12	Эздийн өмчийн дүн	3,103,116,843.05	4,145,977,259.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,740,116,843.05	4,908,812,801.47

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН
---------------	----------	---------------	--------------------

А	Б	2022.12.31.	2023.12.31.
1	Борлуулалтын орлого (цэвэр)	432,279,011.60	246,414,472.09
2	Борлуулалтын өртөг	11,847,587.27	18,343,911.98
3	Нийт ашиг (алдагдал)	420,431,424.33	228,070,560.11
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	20,674,374.00	20,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	53,082,700.72	35,266,940.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	438,191,988.23	390,813,066.70
11	Санхүүгийн зардал	350,000.00	1,800,000.00
12	Бусад зардал	76,601,995.00	141,882,136.42
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	- 127,120,885.62	- 321,691,583.13
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	- 127,120,885.62	- 321,691,583.13
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	- 127,120,885.62	- 321,691,583.13
27	Орлогын нийт дүн	- 127,120,885.62	- 321,691,583.13
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,230,795,673.75	-127,678,830.70	3,103,116,843.05
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	3,230,795,673.75	-127,678,830.70	3,103,116,843.05
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,230,795,673.75	-127,678,830.70	3,103,116,843.05
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	- 321,691,583.13	- 321,691,583.13
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,364,552,000.00	-	1,364,552,000.00
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,595,347,673.75	- 449,370,413.83	4,145,977,259.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	823,700,234.12	449,739,507.45
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	402,697,234.12	177,469,507.45
1.1.6	Бусад мөнгөн орлого	421,003,000.00	272,270,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	806,054,394.56	591,675,237.66
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	117,358,989.33	63,011,442.19

1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	33,674,054.80	18,472,774.47
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	59,192,463.43	21,946,697.91
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	21,496,253.23	30,791,988.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	9,459,649.25	10,338,838.18
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	20,045,512.59	18,871,526.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	544,827,471.93	428,241,970.44
1.2.9.1	Томиолотын зардал		28,990,918.18
1.2.9.2	Шуудан холбооны зардал		11,104,740.21
1.2.9.3	Засварын зардал		7,200,000.00
1.2.9.4	Тоног төхөөрөмжийн түрээсийн зардал		33,345,000.00
1.2.9.5	Зар сурталчилгаа маркетингийн зардал		35,732,124.55
1.2.9.6	Санхүүгийн зардал /аудит төлбөр/		1,800,000.00
1.2.9.7	Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал		436,300.00
1.2.9.8	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал		672,839.09
1.2.9.9	Хамгаалах хувцас хэрэгслийн зардал		3,500,000.00
1.2.9.10	Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал		85,235,276.44
1.2.9.11	Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг		18,343,911.98
1.2.9.12	Бусад зардал		201,880,859.99
1.2.9	Бусад мөнгөн зарлага	544,827,471.93	428,241,970.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,645,839.56	-141,935,730.21
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,674,374.00	20,000,000.00
2.1.6	Хүлээн авсан ногдол ашиг	20,674,374.00	20,000,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	29,106,429.09	23,454,454.55
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,106,429.09	23,454,454.55
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-8,432,055.09	-3,454,454.55
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	155,097,000.00	116,201,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	155,097,000.00	116,201,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	229,000,000.00	165,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	229,000,000.00	165,000,000.00
3.2.5	Бусад зарлага	229,000,000.00	165,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-73,903,000.00	-48,799,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-64,687,215.53	-194,189,184.76

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	270,236,103.22	205,548,887.69
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,548,887.69	11,359,702.93

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	13,000,000.00	13,000,000	100%
2	Цахим Эрдэнэт - 1 хөтөлбөрийн төслийн нэгжийн санхүүжилт	185,000,000.00	185,000,000	100%
3	Пенофасад ХХК-ийн ноогдол ашиг	20,000,000.00	20,000,000	100%
4	Гагнуурын электрод зах зээлд нийлүүлсэний орлого	15,000,000.00	0	0%
5	Менежментийн үйл ажиллагааны орлого	128,500,000.00	77,350,362	60%
6	Гарааны бизнес - 2019 төслийн эргэн төлөлт	4,700,000.00	100,000.00	2%
7	Өрхийн үйлдвэрлэл - 2019 төслийн эргэн төлөлт	43,285,000.00	13,050,000.00	30%
8	Гарааны бизнес - 2020 төслийн эргэн төлөлт	62,118,000.00	26,861,000.00	43%
9	Гарааны бизнес - 2021 төсөлд паркаас оруулсан хөрөнгө оруулалт	24,000,000.00	24,000,000.00	100%
10	Өмнөх оны зарцуулаагүй мөнгөн хөрөнгө	202,816,837.00	202,816,837.00	100%
Нийт дүн		698,419,837.00	562,178,199.00	80.50%
Д/д	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Үндсэн цалин	98,140,000.00	76,748,013.28	78%
2	Ажил олгогчоос НДШ	12,267,500.00	9,554,756.01	78%
3	Бизнес хөгжлийн төвийн дулаан, цэвэр бохир ус	8,450,000.00	8,828,907.16	104%
4	Бизнес хөгжлийн төвийн цахилгаан	3,000,000.00	3,998,322.00	133%
5	Бизнес хөгжлийн төвийн интернет	3,000,000.00	9,785,650.02	326%
6	Байгууллагын үүрэн холбооны дугаар	264,000.00	327,650.00	124%
7	Бизнес инкубаторын дулаан, цэвэр, бохир ус	8,000,000.00	11,028,851.60	138%
8	Бизнес инкубаторын цахилгаан	6,000,000.00	7,195,008.87	120%
9	Бизнес инкубаторын интернет	300,000.00	520,000.00	173%
д	Санхүүгийн програмын лиценз	400,000.00	440,000.00	110%
11	Цахим Эрдэнэт сервер урсгал зардал	14,496,000.00	11,051,175.40	76%
12	Бизнес инкубаторын газрын төлбөр	4,000,000.00	3,672,000.00	92%
13	Санхүүгийн тайлангийн аудит	1,800,000.00	1,800,000.00	100%
14	Цахим Эрдэнэт хөтөлбөрийн мэдээлэл, сурталчилгаа	16,800,000.00	11,875,000.00	71%
15	Эрчим хүчний төлбөр тооцох автомат системийн судалгаа, алгоритм	18,000,000.00	18,000,000.00	100%
16	Төлбөрийн систем хөгжүүлэлт, туршилт, интеграци	17,800,000.00	16,559,500.00	93%
17	Бизнес хөгжлийн төвийн гадна талбайн үерийн уснаас хамгаалах хаалт, нөхөөс	3,000,000.00	3,750,000.00	125%
18	Сурагчдад зориулсан сургагч багш бэлтгэх, сургалт явуулах	3,625,000.00	3,625,000.00	100%
19	Смарт Эрдэнэт платформын өгөгдлийн сангийн зохион байгуулалт	19,200,000.00	21,000,000.00	109%
20	Гадаад, дотоод томилолт	25,000,000.00	29,565,419.00	118%
21	Бичиг хэрэг, хэвлэл	2,400,000.00	2,129,194.00	89%
22	Туршилтын электрод хийх, тоног төхөөрөмж тохируулах түүхий эд	8,000,000.00	-	0%
23	Зах зээлд гаргах электродны сав, баглаа, боодол	2,000,000.00	1,513,500.00	76%

24	Цахим Эрдэнэт серверийн сүлжээний туслах хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	100%
25	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	9,000,000.00	12,375,952.00	138%
26	Хөдөлгүүр, редуктор, удирдлагын систем	10,000,000.00	9,999,900.00	100%
27	Биомасс бутлах ажлын дугуй	8,000,000.00	8,000,000.00	100%
28	Подшипник, суурь	7,000,000.00	7,000,000.00	100%
29	Цэвэрлэгээ, ариутгалын материал	600,000.00	738,963.00	123%
30	Шатахуун, тослох материал	2,520,000.00	3,552,288.00	141%
31	Байгаль орчныг хамгаалах	1,000,000.00	301,390.00	30%
32	Хүнсний үйлдвэрлэлийн төсөлд хөрөнгө оруулалт	110,000,000.00	-	0%
33	ШУА-тай хамтарсан Судлаач энтрепренер хөтөлбөр зохион байгуулалт	5,000,000.00	5,000,000.00	100%
34	Шүүхэд нэхэмжлэл гаргах улсын тэмдэгтийн хураамж	2,160,000.00	-	0%
35	Байгалийн ухаан, инженерчлэлийн сургалтын зардал буцаалт	8,225,000.00	8,225,000.00	100%
36	Томилолтын зардал буцаалт	6,490,000.00	6,490,000.00	100%
37	Ахмадын сан	300,000.00	300,000.00	100%
38	Азийн шинжлэх ухааны паркийн холбооны гишүүнчлэлийн төлбөр	5,000,000.00	-	0%
39	Германы хамтын ажиллагаа бизнес эрхлэгчдэд грант	103,289,000.00	103,289,000.00	100%
40	Германы хамтын ажиллагаа Бизнесийн гарц арга хэмжээ	20,210,000.00	20,210,000.00	100%
41	Смарт Эрдэнэт экспо, маркетинг	107,000,000.00	108,006,937.00	101%
42	Бизнес инкубаторын өвөлжилтийн бэлтгэл	5,700,000.00	6,700,000.00	118%

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 8.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 94.06 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Анхан шатны нотлох баримтгүй “Ухаалаг хотын сурталчилгаа” хийлгэхэд шилжүүлсэн 5.0 сая төгрөг болон гэрээт ажлын хөлсөнд шилжүүлсэн 3.0 сая төгрөгийн зөрчлүүдэд 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу 60.0 сая төгрөгийн Цахим-Эрдэнэт-1 төсөл хөтөлбөрийн зарцуулалт болон 32.9 сая төгрөгийн томилолтын зардлын зарцуулалтад 2 албан шаардлага хүргүүлэхээр болов. Мөн 2022 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй цахилгааны төлбөр 1.1 сая төгрөгийг тайлант онд шилжүүлсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 1.

Харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 3-т "Тооцооны үлдэгдлийн баталгаа НХМаягт", ТМ-3-т "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтөлнө. 2

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллага тус бүртэй тооцоо нийлж, тооцоо нийлсэн актыг үйлдэж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Үүнээс

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шинжлэх ухаан технологийн парк	6	102.6	2	8.0	3	94.06	1	0.0				
Дүн	6	102.6	2	8.0	3	94.06	1	0.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	